

## **ОХУ-ЫН АЛС ДОРНОДЫН БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН АСУУДАЛД**

*К.Дэмбэрэл\**

Улс төрийн түүхэнд бол оршин байгаа төрийн хэлбэрээс түүний үзэл суртал нь хамаарч, энэхүү үзэл суртлаас дотоод, гадаад бодлогын хэлбэр, хэрэгсэл, зорилго хамаарч ирсэн юм байна. Өнөөгийн нөхцөлд Алс Дорнодоо Оросын улс төрийнхний зүгээс өөр, өөр өнцгөөс харж байгаа нь түүнийг янз бүрээр томъёолоход хүргэж байна. Энэ нь эдийн засгийн хөгжлийн тууштай бодлого явуулахад саад болж байгаа.

ОХУ-ын өнөөгийн аж ахуйн хэв шинж нь үйлдвэржилтийн үеийн шинжтэй байгаа ба үйлдвэржилтийн дараахи үед хараахан шилжиж чадаагүй нь түүнийг хөгжсөн орны ангилалд багтаах боломжгүйд хүргэж<sup>1</sup> байна.

Хаант Орос, Зөвлөлт засгийн үед Алс Дорнодын бүс нутгаар дамжин идэвхитэй бодлого явуулж өөрийн ашиг сонирхлыг хамгаалж байсны үр дүнд Оросын нөлөө Ази-Номхон далайд харьцангуй хэвшсэн, төдийгүй улсынхаа зүүн хязгаарт зохих хөгжлийг авчирсан.

ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын зөвлөх И.Ф.Зайцевын гаргасан улс орныхоо нийгэм эдийн засгийн 22 хамгийн чухал харьцуулсан үзүүлэлтээр бол Алс Дорнод, Сибирь нь хамгийн хоцрогдсон бүсэд хамаарч байгаа нь энэ хязгаарт зохих бодлого үгүйлэгдэж буй хэрэг. Үүнийг засч залруулах чиглэлд бодлого үйл ажиллагааг чиглүүлэхийг “цаг үе шаардаж” байна хэмээн оросын судлаачид бичиж байна. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа тусгаж ажил хэрэг болгох ёстойг ч чухалчилан үзэж байна.

ОХУ-ын хувьд асар их баялаг бүхий Сибирь, Алс Дорнодын бүс нутаг нь Азид гарах “нээлттэй хаалга” байж ирсэн. Оросын 17,1 сая хав.дөр. км газар нутгийн 14 сая нь Азид хамаарч тэнд 30 шахам сая иргэд аж төрж байгаа. 2010 оны байдлаар Алс Дорнодын бүс нутгийн гадаад худалдааны нийт эргэлтийн 85 хувь нь Зүүн Азид ноогдож байна.

ОХУ-ын Зүүн Ази, Номхон далайд хуучин байр суурийг сэргээх, бэхжүүлэх талаар оросын геополитикууд санаа тавих боллоо. Энэ талаар гадаад далайд чиглэсэн Оросын бодлого 3 үндсэн чиглэлд байвал зохистойг зарим судлаачид тэмдэглэж<sup>2</sup> байна. Үүнд:

1. Номхон далайн болон Алс Дорнодын хөгжилд Оросын Хойд далайн замыг сэргээх /Северного Морского Пути/ асуудал чухал. Энэ нь ач холбогдолоороо дэлхийд 19-р зуунд оросыг утга зохиолоороо 20-р зуунд түүний нэр нөлөө байр суурь ямар байсан тийм хэмжээнд хүргэхүйц чухал хэмээн үзэж байгаа.

\* К.Дэмбэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

2. Америк, Евразийн холбоо маш чухал гэсэн санааг гаргаж байна. Энд Америк гэдэгт өнөөгийн АНУ биш харин испани, португаль хэлээр яригч Америк тивийг бүхэлд нь Евразитай холбоотон болгох нь Оросыг Номхон далайд тэргүүлэгч болгох нэг чухал хүчин зүйл хэмээн үзсэн.
3. Бүс нутагт идэвхитэй улс төрийн гадаад бодлогыг цэрэг, эдийн засгаар дэмжүүлэн явуулахыг түүх харуулж байгаа. Шаардлагатай үед тухайн бүс нутгийн зарим улсуудтай сөргөлдөөнд орохыг ч үгүйсгэхгүй.

ОХУ нь санхүү, эдийн засгийн байдлаас шалтгаалан Номхон далайд битгий хэл, Зүүн Азид аюулгүй байдлын талбарт нөлөөлж чадахаа больсон ба одоо зөвхөн өөрийн эрэг хавиа буюу Агнуурын тэнгис хавьд эргэлдэх болсон нь Оросын хувьд “эмгэнэл” хэмээн судлаачид бичиж<sup>3</sup> байна. Зарим судлаачдын үзэж буйгаар бол Солонгосын хойгт ч нөлөөгөө алдсан байна. Ингэснээр бүс нутгийн аюулгүй байдлын асуудлыг Хятад, Япон, АНУ л “зохицуулах” болсон байна хэмээн тэд дүгнэж байгаа. Харин бодит байдал бол ОХУ нь эдийн засгийн хүндрэлээс улбаалан бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаас “сайн дураар” тагталзсан хэмээн дүгнэж болох үндэслэл бий. Судлаач П.Салин Алс Дорнод, Зүүн Ази дахь Оросын өнөөгийн байдлыг дараахи хэлбэрээр тодорхойлсон:

- ОХУ-ын хувьд энэ бүс нутагт үлбэгэр, сул байдлаар оролцох болсон
- Энэхүү ирээдүйтэй бүс нутагт хүрч орохгүй байна гэдэг нь түүний глобал байр суурийг сулруулж байгаа гэсэн үг
- Урдын Зөвлөлтийн байр суурийг харахгүйгээр ОХУ-ын сонирхлыг илэрхийлсэн өнцгөөс асуудалд хандах буюу “асуудалд” шинэ хуудаснаас хандаж эхлэх
- Зүүн Азид ОХУ-ын байр суурь урьд хожид байгаагүйгээр унасан. Номхон далайн флотын санхүүжилт нь Хойд далайн санхүүжилтаас харьцангуй бага болсон.
- Бүс нутгийн эдийн засгийн бүтцүүдэд ОХУ нэр төдий оролцох болсон. Эдгээрт оролцох нь нэр төрийн хэрэг гэдэг үүднээс биш ач холбогдол талаас хандахаа больсон.

ОХУ-ын хувьд 2000 оноос Ази тивийг дэлхийн хөгжлийн хөдөлгөгч хүч, түүний үүрэг роль ойрын ирээдүйд өсөн нэмэгдэхийг анхаарч Европ, Азийн бодлогоо тэнцвэржүүлэх чиглэлд өөрчлөлт хийж эхэлсэн.

Сүүлийн жилүүдэд, тухайлбал 2008 оноос ОХУ-ын гадаад улс төрийн бодлогын Азийн чиглэл ч эдийн засгийн боломжоос нь хамааран өөрчлөгдөж байгаа. Азид “манай дотоод, гадаад бодлого нягт уялдаатай байгаа, учир нь эдийн засгийн бат бэх суурьгүйгээр манай гадаад улс төрийн бодлого бүс нутагт явахгүй”<sup>4</sup> хэмээн ОХУ-ын Гадаад

хэргийн сайд С.Лавров тэмдэглэсэн байна. Энэ нь Сибирь, Алс Дорнодын хөгжлийн асуудлаас шууд хамаарна. Алс Дорнодын хөгжил гэдэг нь дэд бүтэц, нийгэм-эдийн засаг зэрэг бусад асуудлаас шууд үүдэлтэй урт хугацааны томоохон санхүүжилт, хүн хүч шаардсан асуудал.

Хэдийгээр судлаачид асуудалд олон ургальч үүднээс хандаж бичиж байгаа ч ОХУ-ын хувьд газар нутгийн аюулгүй байдлын заналхийлал бүс нутгийн улсуудын зүгээс одоохондоо байхгүй, бүс нутгийн хувьд харьцангуй тогтвортой байгаа. Өөрөөр хэлбэл, хил залгаа улсуудын зүгээс ямар нэг аюул учруулж буй зүйл алга. Үүнд тайвширахгүйгээр бодит шинжилгээ хийж үнэхээр тайван байгаа эсэх, энэ байдал хэр удаан үргэлжлэх талаар Оросын үндсэн буюу амин чухал эрх ашиг болох газар нутгийн бүрэн бүтэн байдал, улсын тусгаар бие даасан байдал, батлан хамгаалахын аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал буюу хөгжил хэр хангагдаж байгаад судлаачид дараахи дүгнэлтийг өгсөөр байна. Үүнд:

- Японтой газар нутгийн маргаантай асуудал байгаа ба түүнийг үл тоох маягаар байхын оронд 1993 оны Токиогийн тунхаглалаар асуудал байгаа хэмээн хүлээн зөвшөөрсөн байгаа. Нэгэнт энэ асуудал байгаа тул энэ хоёр улс стратегийн хувьд “өрсөлдөгч” улсууд
- Алс Дорнодын аль ч хэсэгт Хятад, Солонгосын “анклав” бий болгохыг үл тэвчих
- Алс Дорнодын БНУ байгуулах гэсэн салан тусгаарлах үзэл санааг гаргахгүй байх
- Бүс нутгийн аюулгүй байдлын талаархи ОХУ-Япон-АНУ гэсэн “формат”-аас Оросыг алгуур “шахаж” байгааг зогсоох ёстой. Эс тэгвээс ОХУ нь Зүүн Азид аюулгүй байдлын олон улсын субъект байх чадвараа алдана.
- ОХУ-ын дотоод бодлогын тууштай, хэтийг харсан байдлаас Зүүн Азид гарч чадах эсэх нь хамаарах үндэслэлтэй. Өөрөөр хэлбэл, Алс Дорнодын талаар явуулах бодлогоос ихээхэн хамааралтай болоод байна.
- Эдийн засгийн сонирхлоо бүх талаар тууштай хамгаалах, шаардлагатай гэж үзвэл хүч хэрэглэх ёстой

Сибирь, Алс дорнодын нийгэм эдийн засаг, эрчим хүч, хүн ам зүйн, дэд бүтцийн болон экологийн хөгжлийн сайтар боловсруулсан бодлого нь “манай гадаад улс төрийн бодлоготой уялдаж байж л сая жинхэнэ ёсоор “Номхон далайд” гарах бодит гарц”<sup>5</sup> нээгдэнэ. Ингэхлээр асуудал гол нь Оросын дотоод бодлогоос ихээхэн хамааралтай гэдэг нь ойлгомжтой зүйл.

Дэлхий дахины эрчим хүчний аюулгүй байдалд ОХУ-ын хүлээсэн үүрэг, хариуцлагыг ч зөвөөр ухамсарлах ёстой. Бүс нутгийн эрчим хүчний аюулгүй байдал ч үүнд хамаарна. Сибирь, Алс Дорнодын эрчим хүчний эх

сурвалжийг Хятад ч юм уу, АНУ ч юм уу бусад хэн нэгнийг сөргөлдүүлэх хэлбэрээр бус үр ашигтай хамтын ажиллагааны хүрээнд, эрчим хүчний найдвартай нийлүүлэгч байх хэмжээнд л харах ёстой. Энд ОХУ-ын мөрдөгдөж буй “хууль дүрмийг л барихыг шаардах нь манай үүрэг”<sup>6</sup> хэмээн Оросын гадаад хэргийн сайд онцолсон. Эдгээр нь ОХУ-ын Зүүн Ази, Номхон далайд явуулах бодлогыг ерөнхийдөө тодруулж байна хэмээн үзэх үндэслэл билээ. Сибирь, Алс Дорнодод явуулах бодлогоо илүү алсыг харсан хэмжээнд боловсруулахыг өнөөгийн нөхцөл байдал шаардаж байна.

Оросын судалгааны нэр томъёонд ОХУ-ыг “Дорно дахинд нөлөөгөө сэргээхэд Ойрхи болон Дундад Ази, Өмнөд Ази, Зүүн Ази болон Номхон далайн 44 улсад хүрч ажиллахыг” Дорно дахин буюу “Большой Восток”-д эргэн ирлээ хэмээн үзэх үндэстэй хэмээн томъёолж байгаа. Тиймээс Оросын хувьд өнөөгийн байдалтай зогсохгүйгээр Зүүн Азийн бүс нутагт түншээ сонгон, зохих “мега”-төслүүдийг хэрэгжүүлэх нь “Дорно дахин”-д эргэн очих чухал алхам хэмээн судлаач С.Лузянин үзэж<sup>7</sup> байна.

### ДҮГНЭЛТ

Зүүн Азид явуулах Оросын бодлогыг бидний зүгээс тогтмол судлаж, нэн ялангуяа Орос-Хятадын улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны судалгааг түлхүү хийх ёстой.

Оросуудын хувьд Хятадын талаархи судалгаа олон зууны туршид хийсэн арвин туршлагатай төдийгүй өнөөгийн олон ургальч нийгэмд санаа бодлоо нээлттэй илэрхийлэх судлаачид ч цөөнгүй байгааг иш татсан материалаас харж болно. Дотоод, гадаад зардлын бодит харьцааг нягтлан үзэж гадагшаа хандаж явуулах аливаа үйлдэл ямар өртгөөр, ямар үр дагавар авчирч буйг тодорхойлж байх нь чухал.

Оросын эдийн засгийн стратеги нь Хятад, Солонгос, Япон гэсэн улс руу чиглэгдэж байгаа. Зүүн Өмнөд Ази руу улс төр, эдийн засгийн үйл ажиллагааг чиглүүлэх зайлшгүй шаардлага одоохондоо алга байгаа хэмээн зарим экспертүүд бичиж<sup>8</sup> байна. Профессор О.Арины бичснээр, “оросууд бид хүчтэй гэдэг “их гүрний” статусаа хадгалах гэж, хэрвээ тийм статус байхгүй бол түүнийг олж авах гэж улайран батлан хамгаалах салбарт илүү үр дүнгүй зардал гаргах нь манай эмзэгхэн эдийн засгийг хоосруулах хор уршигтай зүйл” хэмээн тэмдэглэсэн байдагтай олон хүн санал нийлж байгаа.

ОХУ-ын хувьд Өрнөд, Дорнодын зөвхөн нэг нь гэсэн туйлширсан бодлого явцгүй байх болно. Европ, Ази, Америкт шууд гарцтай орны хувьд аль аль чиглэлд тууштай, тэнцвэртэй бодлого явуулах нь зүйтэй гэсэн саналыг ОХУ-ын Холбооны Зөвлөлийн гадаад бодлогын хорооны дарга Маргелов тавьж байна.

“Хятадын мөлхөө түрэмгийлэл” гэсэн ойлголт нь ОХУ-ыг НАТО-д тал алдахгүй байдал руу түлхэж байгаа бол НАТО-гийн тэлэлт нь мөн

л ОХУ-ыг Зүүн талдаа “хатуу түшицтэй” байхыг ч сануулж байгаа. ОХУ-ын хувьд энэхүү “гацааны” улмаас Зүүн Азид явуулах бодлого зогсонги байдалд хүрэх нөхцөл гэлтэй. Нөгөө талаас, Өрнөд ч, Хятад ч ОХУ-ыг татахын төлөө тэмцэлдэж байгаа дүр зураг ч гарч байна.

Оросыг Зүүн Азийн интеграцид ч бай, хамтын ажиллагаанд ч бай оруулах талаар санал дэвшүүлж буй судлаачид ч, улс төрчид ч нэг л зүйл дээр санаа нийлээд байгаа нь Оросын Алс Дорнодыг цогцоор нь хөгжүүлэх явдал.

ОХУ нь Зүүн Азийн зах зээл дэх олон улсын хөдөлмөрийн хуваарьт шударга өрсөлдөөний зарчмаар оролцох нь түүний эдийн засгийн хөгжил, аюулгүй байдлын баталгаа болж зөвхөн Европ гэсэн ганц гарцаа хоёр болгох стратегийн ач холбогдолтой юм. ОХУ-ын гадаад улс төрийн үйл ажиллагааны зардал хумигдсаар байгаа ба тэр нь цаашдаа Оросын улс төрийн нөлөөг хумих бодит нөхцлийн гол шалтгаан<sup>9</sup> гэдгийг тодорхойлсон.

Алс Дорнодын бүс нутгаар дамжин Япон, Солонгост гарах Монголын нүүрс болон бусад түүхий эд ч гэсэн Оросын энэхүү бүс нутгийн хөгжилд “зохих хувь нэмрээ” оруулах нь дамжиггүй.

ОХУ-ын Алс Дорнодыг хөгжлийн зохих түвшинд хүргэхгүйгээр Оросыг Зүүн Азид, Номхон далайд байр суурьтай байлгах талаар бодох нөхцөлгүй. Учир нь ОХУ нь Сибирь, Алс Дорнодгүйгээр “хэн ч биш” гэдэг ойлгомжтой бөгөөд ОХУ-ын өнөөгийн дүр төрх ч эргэлзээтэй болно.

### ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Маргелов – ОХУ-ын Холбооны Зөвлөлийн гадаад бодлогын хорооны дарга
2. Крупнов Ю.В. Впервые опубликована в интернет-журнале “Русский Переплёт” /06.05.2002/
3. О.Арин “Азиатско-тихоокеанский регион: мифы, иллюзии и реальность. Восточная Азия: экономика, политика, безопасность” М., 1997
4. Сергей Лавров. “Россия в глобальной политике”. №2, Март – Апрель, 2006
5. Сергей Лавров. “Россия в глобальной политике”. №2, Март – Апрель, 2006
6. Сергей Лавров. “Россия в глобальной политике”. №2, Март – Апрель, 2006
7. “Независимая газета”, # 1 (2555) 14 января 2002 г.
8. О.Арин “Азиатско-тихоокеанский регион: мифы, иллюзии и реальность. Восточная Азия: экономика, политика, безопасность” М., 1997
9. Мөн тэнд